



Зөвлөмжийн Цуврал

АС157-1

Нэмэлт, өөрчлөлт 1 (2)

Аэродром байгуулах, өөрчлөх, нээх ба хаах тухай мэдэгдэх 2016 оны 3 сарын 31

Ерөнхий зүйл

ИНЕГ-ын АС (АС) нь холбогдох ИНД-ийг дагаж мөрдүүлэх зорилгоор Даргын зөвшөөрсөн стандарт, практик, журмуудын талаарх мэдээллийг агуулдаг.

Даргад танилцуулах нийцлийн бусад аргуудыг ч анхаарч үзэх бөгөөд шинээр стандарт, практик, журам хүлээн зөвшөөрөгдөхөд холбогдох АС-д нь нэмж оруулна.

Түүнчлэн, энэхүү АС нь дүрмийн шаардлагыг хангах зааварчилгаа материалыг агуулна. Зааварчилгаа материал нь хүлээн зөвшөөрөхүйц хэлбэрт тооцогдохгүй.

Энд дурдсан дүрмийн дугаар нь ИНД-157-ийн холбогдох дугаартай шууд хамааралтай болно.

Анхаарах

Энэхүү АС нь ИНД-157-ын дагуу ИНЕГ-ын Даргад мэдэгдэх шаардлагатай аэродром байгуулах, өөрчлөх, нээх ба хаахаар төлөвлөж буй аливаа этгээдэд зориулагдсан болно. Мөн зарим агаарын орон зайг ашиглахтай холбоотой хүчин зүйлийг урьдчилан тооцоолох асуудлыг хөндсөн болно.

Зорилго

Энэхүү АС нь ИНД-157-ын дагуу мэдэгдэх шаардлагыг биелүүлэх зааварчилгаа, зөвлөгөөгөөр хангахад оршино.

Хамааралтай дүрмүүд

Энэхүү АС нь ялангуяа 157.7-д харилцан хамааралтай.

Өөрчлөлтийн мэдэгдэл

Гишүүн улсуудын ИНД-ийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 дугаар сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын ИНДБ-ийг боловсруулсан.

ИНД-157-г монгол болон англи хэл дээр боловсруулсан болно. Эдгээрийн хооронд зөрүү гарсан тохиолдолд англи хувилбартай харьцуулна.

АС157-1-ийг NZ АС157-1-ийн 2007 оны 4 сарын 27-ны өөрчлөлт 2-т үндэслэн боловсруулсан болно.

Гарчиг

1. Мэдэгдэх шаардлага	4
2. Аэродром болон хэлипортын үйлчлэх хүрээ	4
3. Тодорхойлолт	5
4. Мэдэгдэл хийх шаардлагатай төсөл	5
5. Мэдэгдлийг хэрхэн гаргах.....	5
6. Агаарын зайн ашиглалтын асуудал	5
7. Сонирхогч этгээдтэй зөвлөлдөх.....	6
8. Шийдвэр	6
9. Аэродромын зураглал.....	7
10. Шийдвэрийн хүчинтэй хугацаа	7
11. Шийдвэрийг дахин авч үзэх.....	7
12. Гүйцэтгэлийн талаар мэдэгдэх.....	7
13. Аэродром болон хэлипортын өгөгдөл ба мэдээллийг түгээх.....	7
14. Төлөвлөлтийн явцад өгөх зөвлөмж.....	8
15. Бусад хуулийн шаардлага	8
Хавсралт 1 - САА 24157/01 маягт	9

1. Мэдэгдэх шаардлага

1.1 ИНД-157-ээр, аливаа этгээд аэродром байгуулах, өөрчлөх, нээх, эсхүл хаах тохиолдолд Даргад урьдчилан мэдэгдэж байхыг шаардсан байдаг. Энэ мэдэгдэл нь санал болгож байгаа аэродромтай холбоотой агаарын зайн ашиглалт бусад тогтоосон агаарын зайн хэрэглэгчдэд аюултай болох эсэхийг тогтоох боломжийг олгоно. Мөн газарт байгаа хүн болон өмч хөрөнгийн аюулгүй байдалд аюул учруулах хүндрэлтэй асуудлыг тогтооход тусална.

1.2 Агаарын зайг үр ашигтай ашиглах талаар урьдчилан тооцоолсон байх шаардлагатай. Дээрх мэдэгдлийг хүлээн авсны дараа Дарга тухайн саналын агаарын хөлөг ашиглах агаарын зай болон газарт байгаа хүн болон өмч хөрөнгийн аюулгүй байдалд үзүүлэх нөлөөллийг тооцсон зөвлөмжийг өгнө.

1.3 Дарга мэдэгдэл хүргүүлсэн бүх аэродромын өгөгдлийг хадгалах ба ингэснээр аэродром бүрийн ашиглаж байгаа агаарын зайг шинэ аэродром, нам өндрийн нислэгийн бүс, батлан хамгаалах дасгал сургуулилт болон түүнтэй ижил үйл ажиллагаанд санал болгосон агаарын зайн ашиглалтад авч үзнэ .

2. Аэродром болон хэлипортын үйлчлэх хүрээ

2.1 ИНД-157 нь дараахаас бусад тохиолдолд, аэродром, эсхүл хэлипорт бүрд үйлчлэхгүй.

(a) ИНД-139-ийн дагуу гэрчилгээжсэн байх шаардлагатай аэродром (энэ аэродром нь гэрчилгээжүүлэлтийн дүрмийн дагуу зохицуулагдана); эсхүл

(b) Үргэлжилсэн 30 хоногт 7-оос дээшгүй өдөр ашигладаг, эсхүл ашиглахад зориулсан, VFR-аар үйл ажиллагаа нь хязгаарлагддаг аэродром, эсхүл хэлипорт; эсхүл

(c) Зөвхөн ХАА-н агаарын хөлөгт ашигладаг, эсхүл ашиглахад зориулсан, нислэгийн хөдөлгөөний удирдлагын бүсэд байрлаагүй дараах аэродром:

- (i) хамгийн ойр байрлах бусад аэродромоос 9 км-ээс (5 nm) багагүй зайд байрладаг; болон
- (ii) хамгийн ойр байрлах хэлипортоос 6 км-ээс (3 nm) доошгүй зайд байрладаг. эсхүл

(d) Зөвхөн ХАА-н нисдэг тэрэг ашигладаг, эсхүл ашиглахад зориулсан нислэгийн хөдөлгөөний удирдлагын бүсэд байрлаагүй дараах хэлипорт:

- (i) хамгийн ойр байрлах бусад аэродромоос 6 км-ээс (3 nm) багагүй зайд байрладаг; болон
- (ii) хамгийн ойр байрлах хэлипортоос 2 км-ээс (1 nm) багагүй зайд байрладаг.

3. Тодорхойлолт

ИНД-157-д аэродром болон хэлипортыг өөрөөр авч үздэг тул ИНД-1-ээс өөрөөр тодорхойлсон байдаг. ИНД-157-д дараах байдлаар тодорхойлсон:

Аэродром гэдэгт нисдэг тэргэнд зориулан тогтоосон, эсхүл зураг төслөөр төлөвлөгдсөн тодорхой хуурай эсвэл усан гадаргуу хамаарахгүй

Хэлипорт гэдэгт нисдэг тэргэнд зориулагдсан, эсхүл төлөвлөгдсөн хуурай, эсхүл усан гадаргуу, байгууламж дээрх тогтоогдсон бүх гадаргуунууд хамаарна.

4. Мэдэгдэл хийх шаардлагатай төсөл

Дараах ажлыг хэрэгжүүлэхээр зорьж байгаа этгээд /Цаашид хүсэлт гаргагч гэх/ нь 157-д шаардсаны дагуу ИНЕГ-ын Даргад мэдэгдлийг хүргүүлнэ.

(a) ИНД-157 хамаарах аэродром, эсхүл хэлипортыг байгуулах, эсхүл бусад хэлбэрээр бий болгох, эсхүл ийм аэродром, эсхүл хэлипортыг ажиллуулах.

(b) ИНД-157 хамаарах аэродром, эсхүл хэлипортын ХБЗ, эсхүл бусад агаарын хөлгийн хөөрөлт, эсхүл буултын талбайг байгуулах, чиглэл өөрчлөх, өөрчлөх, эсхүл ажилд оруулах:

(c) ИНД-157 хамаарах аэродром, эсхүл хэлипортыг, эсхүл тухайн аэродром, эсхүл хэлипортын хөөрөлт, эсхүл буултын талбайг нэг жил, эсхүл түүнээс дээш хугацаагаар хаах, ашиглалтыг зогсоох, эсхүл татгалзах.

5. Мэдэгдлийг хэрхэн гаргах

5.1 Аэродром, эсхүл хэлипортыг байгуулах, өөрчлөх болон нээх мэдэгдлийг тухайн ажил эхлэх өдрөөс 90-ээс доошгүй хоногийн өмнө САА 24157/01 маягтын дагуу ИНЕГ-ын Даргад хүргүүлсэн байна.

5.2 Аэродром, эсхүл хэлипортыг, эсхүл тухайн аэродром, хэлипортын хөөрөлт, эсхүл буултын талбайг хаах, ашиглалтыг зогсоох, эсхүл татгалзахаар төлөвлөсөн өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө Даргад бичгээр хүргүүлсэн байна.

5.3 САА 24157/01 маягтын хуулбарыг ИНЕГ-аас авах боломжтой. Маягтын загвар болон бөглөх зааврыг Хавсралт 1-д харуулсан байх ба мэдэгдэл ирүүлэхдээ уг маягыг ашиглаж болно.

6. Агаарын зайн ашиглалтын асуудал

Дарга нь ИНД-157-ын дагуу ирүүлсэн мэдэгдэл бүрд нисэхийн судалгааг хийнэ. Энэ нь санал болгосон аэродром, эсхүл хэлипорт нь агаарын зайд агаарын хөлгийг аюулгүй, үр ашигтай ашиглах болон газарт байгаа хүн, өмч хөрөнгийн аюулгүй байдалд үзүүлэх нөлөөллийг тодорхойлно. Судалгаанд дараах хүчин зүйлийг анхаарч үзнэ:

(a) шинээр төлөвлөж байгаа болон одоо байгаа аэродром, эсхүл хэлипорт нь хөрш аэродром, эсхүл хэлипортын хөдөлгөөний хайрцагт хэрхэн нөлөөлөх;

(b) одоо байгаа болон төлөвлөж байгаа агаарын зайн ашиглалт;

- (c) одоо байгаа болон хүний гараар бүтээхээр санал болгосон объект;
- (d) холбогдох газар нутагт байгаа байгалийн объект болон онцлох зүйл;
- (e) холбогдох газар нутагт байгаа хүн болон өмч хөрөнгө;
- (f) тухайн аэродром, эсхүл санал болгож байгаа хэлипортыг байгуулахад хэрэгтэй бусад нисэхийн шаардлагад нийцүүлэх
- (g) агаарын зайн аюултай, эсхүл үр ашиггүй ашиглалтыг арилгахад шаардлагатай байж болох, тухайн аэродром, эсхүл санал болгож байгаа хэлипортыг боломжоор хянаж шалгах.

7. Сонирхогч этгээдтэй зөвлөлдөх

Нисэхийн судалгааны хүрээнд Дарга 157.9(b)-ийн дагуу хамааралтай гэж үзсэн иргэд, төлөөллийн бүлэг болон байгууллагатай зөвлөлдөнө. Энэ нь харилцан ярилцлага, хурал, албан бус уулзалт, эсхүл төлөвлөсөн ажил, гүйцэтгэх хугацааг тусгасан АС-ыг түгээж иргэдээс санал хүсэлтийг авах хэлбэрээр байж болно.

8. Шийдвэр

8.1 Нисэхийн судалгаа хийх зорилго нь Даргын гаргасан шийдвэрийн хэлбэрээр зөвлөгөө өгөхөд оршино. Эдгээр шийдвэрийг дараах аль нэг хэлбэрээр гаргана:

- (a) **Татгалзах зүйлгүй:** санал болгосон ажиллагаа нь агаарын зайд агаарын хөлгийг аюулгүй, үр ашигтай ашиглах болон газарт байгаа хүн, өмч хөрөнгийн аюулгүй байдал, хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлөхгүй гэж үзвэл Дарга “татгалзах зүйлгүй” гэсэн шийдвэр гаргана.
- (b) **Нөхцөл заасан:** санал болгосон ажиллагааны хүлээн авах боломжгүй хүчин зүйлийг тогтоон, хэрэв тодорхой заасан нөхцөлийг дагаж мөрдсөн тохиолдолд, санал болгосон ажиллагаа нь агаарын зайд агаарын хөлгийг аюулгүй, үр ашигтай ашиглах, газарт байгаа хүн, өмч хөрөнгийн аюулгүй байдал болон хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлөхгүй гэж үзвэл Дарга “нөхцөл заасан” шийдвэр гаргана.
- (c) **Хүлээн авах боломжгүй:** Дарга санал болгосон ажиллагааг хүлээн авах боломжгүй шалтгааныг тогтоовол “хүлээн авах боломжгүй” гэсэн шийдвэр гаргах ба шалтгааныг тодорхой заана.

8.2 Дарга хүлээн авах боломжгүй шийдвэр гаргах тохиолдолд арга хэмжээ авна. Дарга агаарын зайн аливаа аюултай ашиглалтыг арилгах арга хэмжээ авна. Даргын зөвлөмж нь иргэний нисэхийн тогтолцооны аюулгүй байдлыг бүхэлд нь хангахтай холбоотой тул хамаарал бүхий этгээд хүлээн авч, хүндэтгэлтэй хандах ёстой.

8.3 Орон нутгийн удирдлага нь холбогдох хуулийн дагуу тухайн нутгийн газар ашиглалтад хяналт тавина. Дарга тухайн орон нутгийн удирдлагуудтай санал болгосон аэродром, хэлипорт болон нислэг үйлдэх агаарын зайд нөлөөлөх объектод холбоотой хийгдэх ажиллагаанд хамтран ажиллах харилцаа холбоог тогтооно. Нисэхийн судалгааны явцад холбогдох орон нутгийн байгууллагыг татан оролцуулах бөгөөд тухайн орон нутгийн удирдлага нь Даргын хүлээн авах боломжгүй шийдвэрээр зарим зүйлийг хориглож болохыг анхаарах хэрэгтэй.

8.4 Шийдвэрийг хамаарал бүхий этгээд, зохих орон нутгийн удирдлага болон бусад сонирхогч хүмүүст хүргүүлнэ.

9. Аэродромын зураглал

9.1 Нисэхийн судалгааны хүрээнд Дарга дараах зорилгоор тухайн аэродром, эсхүл хэлипортын байршлыг нислэгийн зурагт үзүүлэх шаардлагатай эсэхийг тогтооно:

- (a) дээгүүр нисэх өнгөрч байгаа агаарын хөлөгт аэродром, эсхүл хэлипортын байдлыг мэдээлэх;
- (b) аэродром, эсхүл хэлипортын навигацийн үйлчилгээнд;
- (c) онцгой нөхцөлд аэродром, эсхүл хэлипортыг ашиглахад бэлэн байгааг харуулах.

9.2 Бусад байгуулсан аэродром, эсхүл хэлипортоос алслагдсан зайд байрлах санал болгосон аэродром, эсхүл хэлипорт нь гуравдагч этгээдэд эрсдэл үүсгэхгүй болохыг нисэхийн судалгаагаар тогтоож өөрөөр шаардаагүй үед зураглалд үзүүлнэ.

10. Шийдвэрийн хүчинтэй хугацаа

Татгалзах зүйлгүй болон нөхцөл заасан аэродром, эсхүл хэлипортын шийдвэр нь хүчингүй болгох хугацааг заасан байна. Аэродромыг дэс дараалалтай төлөвлөх болон агаарын зайн шаардлагагүй хамгаалалтыг арилгах зорилгоор хүчингүй болгох хугацааг заадаг. Гэсэн хэдий ч, хүчингүй болгох хугацааг сунгуулахаар Даргад хүсэлт гаргаж болно. Хэрэв тогтоосон хугацаанд тухайн ажлыг дуусгаагүй шалтгаан бодитой байхын бол Дарга бүх хүсэлтийг анхаарч үзнэ.

11. Шийдвэрийг дахин авч үзэх

Сонирхогч этгээд нь шийдвэрийн хүчингүй болгох хугацаанаас 15-аас доошгүй хоногийн өмнө шийдвэрийг дахин авч үзэх хүсэлтийг Даргад гаргана. Дарга тухайн шийдвэр гаргасан үндэслэлийг өөрчлөх шинэ баримтыг анхаарч үзнэ.

12. Гүйцэтгэлийн талаар мэдэгдэл

Санал болгосон аэродром, эсхүл хэлипортыг байгуулах, өөрчлөх, нээхэд оролцсон хамаарал бүхий этгээд тухайн ажил дууссанаас хойш 15 хоногийн дотор Даргад бичгээр мэдэгдэх ёстой.

13. Аэродром болон хэлипортын өгөгдөл ба мэдээллийг түгээх

Гэрчилгээждэггүй аэродром, болон хэлипортын үйл ажиллагаа эрхлэгч нь холбогдох өгөгдөл болон мэдээллийг Нисэхийн мэдээллийн эмхтгэлээр зарлуулна. Энэ нь агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчид, ялангуяа агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэгчид ИНД-139-ийн шаардлагат аэродром болон хэлипортын ашиглалтыг нийцүүлэхэд тусална. Иймд аэродром, эсхүл хэлипортын үйл ажиллагаа эрхлэгч нь АС139/09-ийн дагуу аэродромын өгөгдөл болон мэдээллийг дэлгэрэнгүйгээр, захиргааны үйл ажиллагааны хамт Нисэхийн мэдээлэл үйлчилгээний албанд ирүүлэх ёстой.

14. Төлөвлөлтийн явцад өгөх зөвлөмж

Дарга төслийн төлөвлөлтийн үе шатуудад агаарын зайн ашиглалт талаас төслийн биелэлтэд зөвлөмжөөр хангаж ажиллана. Аливаа төсөл хэрэгжүүлэх, тэр дундаа шинээр аэродром болон хэлипорт барих үед тухайн төслийг санхүүжүүлэгч, хөрөнгө оруулагч тал өмч хөрөнгө худалдан авах ба инженерийн шийдэлд мөнгөө зарцуулахаас урьтаж холбогдох зөвлөмжийг авах тухайд санаачилга гаргана. Тухайн зөвлөмж нь албан бус хэлбэртэй ба хэрэв хамаарал бүхий этгээд тухайлан хүсээгүй бол төлөвлөсөн ажлыг олон нийтэд түгээхгүй.

15. Бусад хуулийн шаардлага

Даргын шийдвэр нь тухайн орон нутгийн дүрэм, журам, иргэний нисэхийн бусад дүрмээс давж гарахгүй. Аэродром болон хэлипортын төсөлд оролцогч этгээд нь тухайн хүрээлэн буй орчинд хамаарах хууль эрх зүйн шаардлагыг судалсан байх ёстой бөгөөд энэ нь төсөл амжилттай хэрэгжих болон төлөвлөгөө гацахтай холбоотой юм. Эдгээр асуудлыг зохицуулах нь төсөлд оролцогчийн үүрэг бөгөөд Дарга хариуцахгүй.

Хавсралт 1 - САА 24157/01 Маягт**САНАЛ БОЛГОЖ БАЙГАА АЭРОДРОМ/ХЭЛИПОРТЫН АЖЛЫН МЭДЭГДЭЛ**

1. Аэродром/хэлипортын үйл ажиллагаа эрхлэгчийн талаарх мэдээлэл:

а. Нэр (хувь хүн, эсхүл байгууллага)					
б. Хаяг:					
Утас:					
			Факс:		

2. Аэродром/хэлипортын талаарх мэдээлэл:

а. Аэродром / хэлипортын нэр					
б. Аэродром / хэлипортын байршил заагч:					
в. Байгууламжийн төрөл: Аэродром		Хэлипорт			
г. Ойролцоох хот, эсхүл суурин газар					
д. Орон нутгийн удирдлага					
е. Ойролцоох хот, эсхүл суурин газар хүртэлх зай болон чиглэл		км	Чиглэл		
ж. Өргөрөг		Уртраг:		Өндөрлөг	

Тэмдэглэл: НМЭ-ээр зарлагдах бүх аэродромууд 4 үсгийн кодтой байна. Кодыг авах хүсэлтийг САА241DA маягтаар авна.

3. Хүсэлт гаргах шалтгаан

а. Шинээр барих, эсхүл байгуулах Construction or Establishment		Өөрчлөх Alteration		
б. Хэрэв шинээр барьж байгаа бол нээх огноо Activation Date if Construction or Establishment				
в. Хэрэв өөрчлөлт оруулж байгаа бол өөрчлөлтийг бичих If Alteration, describe change				

4. Аэродром / хэлипортын өгөгдөл

Аэродром Aerodrome			
а. ХБЗ-ны соронзон чиглэл			
б. ХБЗ-ны урт			
в. ХБЗ-ны гадаргуугийн төрөл			
Хэлипорт			

а. Хэмжээ (TALO)			
б. Хэмжээ (FATO)			
в. Гадаргуугийн төрөл Type of surface (Turf, Rooftop, etc)			
г. Ойртолт ба хөөрөлт үйлдэх замын соронзон чиглэл			

5. Үйл ажиллагааны талаарх мэдээлэл

а. Сар тутамд үйлдэх буултын дундаж тоо	Одоо байгаа		Санал болгосон	
Агаарын тээвэр				
Бусад				
б. ХНД-аар нислэг үйлдэгдэх эсэх Are IFR Operations Anticipated	Тийм		Үгүй	
Жилийн хугацаанд		Навигацийн туслах төхөөрөмжийн төрөл		

6. Нисэхийн судалгааны талаарх мэдээлэл

а. 5 миль дотор ИХНД-р нислэг үйлддэг бүх бүх аэродром/хэлипорт, 10 миль дотор ХНД-р нислэг үйлддэг бүх аэродромын жагсаалт List all VFR aerodromes and heliports within 5 nm, and all IFR Aerodromes within 10 nm			
Аэродром / Хэлипортын нэр	Зай	Чиглэл	
б. VFR-р нислэг үйлдэх аэродромын хувьд 5.6 км (3 nm) доторх саад, IFR-р нислэг үйлдэх аэродромын хувьд 9 км (5 nm) доторх саад, болон хэлипортын хувьд хөөрч буух талбайн хязгаараас 5000 ft доторх саадын жагсаалт List, and plot on a suitable map, any obstructions within a 3 nm radius for VFR Aerodromes and 5 nm for IFR Aerodromes, and, for Heliports, within 5000 ft of the perimeter of the Landing and Take-off Area.			
Саадын төрөл	Аэродром/хэлипортоос дээш өндөр	Чиглэл	Зай
в. Аэродромоос 3.6 км (2 nm) 2 радиус доторх, хэлипортоос 1.8 км- (1 nm) радиус доторх сургууль, сүм дуган, эмнэлэг зэрэг болон орон сууцны хорооллуудын жагсаалт List any Schools, Churches, hospitals, etc, and Residential areas within 2 nm radius for Aerodromes and 1 nm radius for Heliports			
Байгууламжийн нэр	Чиглэл	Зай	

7. Баталгаа

Дээрх бүх мэдээлэл үнэн зөв гэдгийг би баталж байна.

I hereby certify that all the above statements made by me are true and complete to the best of my knowledge.

Нэр

Гарын үсэг

Огноо

Аэродром/Хэлипортын төлөвлөсөн ажлыг мэдүүлэх заавар

Дараах ажлыг гүйцэтгэхээр төлөвлөсөн этгээд нь ИНД-157-гийн дагуу ИНЕГ-т мэдэгдэнэ.

1. ИНД-157 хамаарах аэродром, эсхүл хэлипортыг байгуулах, эсхүл бусад хэлбэрээр бий болгох, эсхүл ийм аэродром, эсхүл хэлипортыг ажиллуулах.
2. ИНД-157 хамаарах аэродром, эсхүл хэлипортын ХБЗ, эсхүл бусад агаарын хөлгийн хөөрөлт, эсхүл буултын талбайг байгуулах, чиглэл өөрчлөх, өөрчлөх, эсхүл ажилд оруулах

Дараах хаягаар маягтыг мэдүүлнэ.

ИНЕГ, ДБХ

17120, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо, Буянт-Ухаа

ЕРӨНХИЙ ЗААВАР

1. Дээр заагдсан 1 дүгээр бүлэгт хамаарах бүх төслийн хувьд маягтын холбогдох бүх зүйлийг бөглөнө.
2. 2 дугаар бүлэгт хамаарах төслийн хувьд маягтын 1, 2а, 2б, 3, 4 ба 7 бөглөнө.
3. Чиглэлийг соронзонгоор болон зайг км-ээр үзүүлнэ.
4. Маягтанд газрын зураг болон түүнтэй дүйцэх зураглалыг хавсаргана. ХБЗ-ны чиглэлийн өөрчлөлт болон холбогдох явгалах замын байршлыг үзүүлсэн хэвлэмэл зураг. Шаардлагатай тохиолдолд хэлипортын хотын зураглалыг ашиглана.
5. Бүх зүйлийг хэвлэсэн, эсхүл бичсэн байх, бүх хуулбар бодит болохыг нягтална уу.